



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 14 өдөр

Дугаар А 201

Номгон

Эрүүл мэндийн төлөө "Цаг гаргая" аяныг  
зохион байгуулах тухай


Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй "Эрүүл Монгол хүн" үндэсний хөдөлгөөн, "Алсын хараа 2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын 2020-2024 оны мөрийн хөтөлбөр, Биеийн тамир, спортын улсын хорооны 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 1/257 дугаар тушаалаар батлагдсан "Цаг гаргая" аян, "Эрүүл амьдрал-Идэвхтэй хөдөлгөөн" арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөг батлах тухай 12/54 дугаар тогтоолын хавсралтын 6.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Эрүүл амьдрал-Идэвхтэй хөдөлгөөн" арга хэмжээний хүрээнд, Эрүүл мэндийн төлөө "Цаг гаргая" аяныг 2023 оны 04 дүгээр сарын 13-ны өдрөөс 06 дугаар сарын 24-ний хооронд зохион байгуулсугай.

2.Дээрх үйл ажиллагаанд зарцуулагдах 10.000.000 (Арван сая) төгрөгийг Аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргаж Биеийн тамир, спортын газарт шилжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа) -т зөвшөөрсүгэй.

3.Ажлыг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Б.Наранбаяр), Биеийн тамир, спортын газар (Б.Оюунбаатар) нарт тус тус үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Батсуурь)-д даалгасугай.



ДАРГА

Д.МӨНХСАЙХАН

642310511